



# МҮХАҮТ

## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ



2023.02.01

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Дугаар / 23.01



### Шилдэг аж ахуйн нэгжүүдийн тугийг мандууллаа



#### ДАРААГИЙН НҮҮРЭНД ...>



"Эрдэнэс Монгол" ХХК-ийн нээлттэй сонгон шалгаруулалтын ярилцлагын шалгалтыг зохион байгуулж байна



МҮХАҮТ-ын 42 төлөөлөгч 22 улсад ажиллаж байна



Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засаг болон шилжилт хөдөлгөөний системийн динамик загварыг боловсруулна



"Хариуцлагатай бизнес, шударга байдлын аргачлал хэвшүүлэх" сургалт боллоо



Бизнес Академи "Харвард бизнесийн сургууль"-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна



Шинэ гишүүний гэрчилгээ гардуулах ёслол боллоо



"The Asia-Pacific Woman Entrepreneur Award" шагнал гардууллаа



Бизнесийн салбарын нэр хүнд, үнэ цэнийг тодорхойлж ирсэн Монгол Улсын оны онцлох аж ахуйн нэгжийг шалгаруулдаг "Entrepreneur 2022" Меркури цом гардуулах ёслолын "Гран при" Алтан Меркури шагналын эзэн "Оюу толгой" ХХК, Ази, Номхон далайн орнуудын ХАҮТ-уудын нэгдсэн Холбооны шагналаар шагнагдсан "Интернейшнл

Медикал Сентер" ХХК болон шилдэг аж ахуйн нэгжээр шалгарсан "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, "Энержи Ресурс" ХХК, "ХААН" банк, "Номин Холдинг" ХХК, "Мобиком корпораци" ХХК, "Сүү" ХК, "М-Си-Эс Кока-Кола" ХХК, "Тэсо" ХХК, "Петровис групп" ХХК, "Грийн групп" ХХК-ийн тугийг мандууллаа.

### "EXECUTIVE SUMMIT 2023"

гүйцэтгэх дээд удирдлагуудын уулзалт 2 дугаар сарын 9-нд МҮХАҮТ-д болно





## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

**“Executive summit 2023” гүйцэтгэх дээд удирдлагуудын уулзалт  
2 дугаар сарын 9–нд МҮХАҮТ–д болно**

Энэ удаагийн уулзалтаар:

“Challenge and change” сэдвээр  
“Pennsylvania University, Wharton School”  
–ийн профессор KATY MILKMAN

“Collaborative leadership & Quality” сэдвээр  
“Harvard Business School Publishing” – ийн  
Бүсийн захирал PERDEEP KUMAR

“Corporate Governance” сэдвээр Английн  
“Institute of Directors” –ийн Бодлого &  
Компанийн засаглал хариуцсан захирал  
ROGER BARKER

зэрэг олон улсын шилдэг судлаач,  
эрдэмтэд болон үндэсний лидерүүд  
илтгэл тавьж, сонирхолтой хэлэлцүүлэг,  
ярилцлага өрнүүлнэ.

Хөгжлийн төлөөх өөрчлөлттэй хөл  
нийлүүлэн алхаж, шинэлэг мэдлэг,  
мэдээлэл авч, тасралтгүй хөгжиж,  
өөрчлөлтийн төлөө нэгдэцгээе.

**ТӨЛБӨР: 150\$,**  
**/2023.02–06 – аас өмнө бүртгүүлбэл 100\$/**  
**Утас: 80583888, 99031573, 88052755**

**“Эрдэнэс Монгол” ХХК–ийн нээлттэй  
сонгон шалгаруулалтын ярилцлагын  
шалгалтыг зохион байгуулж байна**

Нээлттэй сонгон шалгаруулалтын  
ярилцлагын шалгалтыг зохион  
байгуулах дэд ажлын хэсгийг МҮХАҮТ  
ахлан, 2023 оны 1 дүгээр сарын 30–наас  
2 дугаар сарын 2–ны өдрүүдэд өөрийн  
байрандаа зохион байгуулж байна. 71  
ажлын байрны 88 орон тоонд  
давхардаагүй тоогоор 1215 иргэн  
сорилын шалгалт өгснөөс өндөр оноо  
авсан 434 иргэн ярилцлагын шалгалтад  
оролцож байна.

Ярилцлагын үйл явцад хөндлөнгийн  
шинжээчид хяналт тавин ажиллаж  
байна. Ярилцлага нь “Эрдэнэс Монгол”  
ХХК–ийн нөөц бүрдүүлэх нээлттэй  
ажлын байранд сонгон шалгаруулах  
сүүлийн шат. Сорилын болон  
ярилцлагын шатны шалгалтын нийлбэр  
дүнгээр хамгийн өндөр оноо авсан нэр  
дэвшигчдийг “Эрдэнэс Монгол” ХХК–  
ийн Гүйцэтгэх удирдлага сонгогдсон  
албан тушаалд томилно.

**МҮХАҮТ–ын 42 төлөөлөгч 22 улсад  
ажиллаж байна**

МҮХАҮТ нь гадаад улс, орнуудтай эдийн  
засаг, худалдаа, бизнесийн харилцааг  
хөгжүүлэх, бизнес эрхлэгчдийн  
түншлэлийг өргөжүүлэх зорилтын  
хүрээнд төлөөлөгч нарыг томилон  
ажиллуулж ирсэн. Гадаад улс орнууд

дахь төлөөлөгчдийн цахим хурал болж,  
2023 онд хийж гүйцэтгэх ажлын  
төлөвлөгөөгөө батлуулах, гэрээгээ  
шинэчлэн байгуулах, мөн шаардлагатай  
мэдээ, мэдээллээр авах зэрэг  
асуудлуудыг хэлэлцлээ.

**Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засаг  
болон шилжилт хөдөлгөөний  
системийн динамик загварыг  
боловсруулна**

МҮХАҮТ болон Хөвсгөл аймгийн Засаг  
даргын Тамгын газар хамтран Хөвсгөл  
аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль  
орчны үндсэн үзүүлэлтүүд, эдгээрийг  
2040 он хүртэлх хэтийн төсөөлөл,  
хөгжил дэвшил, бодлого, төлөвлөлтийг

симуляцийн /тоон өгөгдөл дээр хийсэн  
автоматик дүн шинжилгээ/ туршилт,  
загвар ашиглан олон улсын жишиг  
загвараар дүгнэн гаргах системийн  
динамик загварыг боловсруулах ажлыг  
эхлүүлээ.



## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

### “Хариуцлагатай бизнес, шударга байдлын аргачлал хэвшүүлэх” сургалт боллоо



МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнесийн ёс зүйн төв “Хариуцлагатай бизнес, шударга байдлын аргачлал хэвшүүлэх” сэдэвт сургалтыг 23-наас 24-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Тус сургалт нь бизнесийн үйл ажиллагаа явуулахад тулгамддаг авлига, ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох, тухайн нөхцөл үүсэх үед баримтлах бизнесийн ёс зүйн стандартыг хэвшүүлэх, олон улсын сайн жишгийг нэвтрүүлэх, практикт суурилсан мэдлэг, чадвар олгоход чиглэгдсэн онцлогтой

сургалт боллоо.

Сургалтад “Говь” ХК, “Скайтел” ХХК, “МИК”, “Инвектор ББСБ” ХК, “Макс Рөүдс” ХХК, “Капитрон” банк, АТГ зэрэг төр, хувийн хэвшил болон олон улсын байгууллагын төлөөлөл оролцсон ба байгууллагуудын төлөөллүүд бизнесийн ёс зүй, комплаенсын талаар мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэхийн зэрэгцээ байгууллагадаа хэрэгжүүлж буй бодит туршлагаа хуваалцан санал солилцов.

### Бизнес Академи “Харвард бизнесийн сургууль”-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна

МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес академийн захирал Д.Асралт “Харвард бизнесийн сургууль”-ийн захиалгат хөтөлбөр хариуцсан захирал Кларк болон профессор Форест Рейнхардтай уулзаж, 2023 онд үргэлжлүүлэн хамтран ажиллахаар тохиролцлоо.

Харвардын 122 хөтөлбөрт жилд дунджаар 13 мянган гаруй захирал суралцдаг байна. Бизнес Академи гүйцэтгэх удирдлагуудад зориулсан богино хугацааны, бизнесийн салбарын хамгийн сүүлийн үеийн мэдлэг, мэдээлэл олж авах, бодит кейс ажиллах,

ижил түвшний манлайлагчдаас суралцах, нетворкинг хийх боломжтой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллахаар ярилцжээ. Мөн EXECUTIVE SUMMIT-2023 арга хэмжээг “Өөрчлөлтөөр манлайлъя” сэдвийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөсөн байна.



### Шинэ гишүүний гэрчилгээ гардуулах ёслол боллоо

МҮХАҮТ-д 2022 оны 4-р улиралд шинээр элссэн болон гишүүний ангилал дээшлүүлсэн компаниудад МҮХАҮТ-ын Гишүүнчлэлийн газрын дарга Ц.Магнайбаатар Гишүүний гэрчилгээг гардууллаа.

Мөн энэ үеэр МҮХАҮТ-ын Патент, барааны тэмдэг, газар зүйн заалтын газрын дарга С.Дүүрэнжаргал “Оюуны өмчийн ерөнхий ойлголт”, ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг

зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар төрөөс баримталж буй бодлого болон Ахмад настны хуулийг хэрэгжүүлэхэд ажил олгогч нар анхаарах асуудлууд”, Төрийн банкны Бүтээгдэхүүн хариуцсан мэргэжилтэн А.Содномпэлжээ “Санхүүгийн боловсрол”-ын талаар тус тус танилцуулга хийв.



### “The Asia Pacific Woman Entrepreneur Award” шагнал гардууллаа

Ази, Номхон далайн Худалдаа, аж үйлдвэрийн танхимуудын холбоо (CASSI)-оос тус бүс нутгийн шилдэг бизнес эрхлэгч эмэгтэйд олгодог “The Asia-Pacific Woman Entrepreneur Award” шагналыг Монгол Улсаас “Монолаб” ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Оюундэлгэр хүртлээ.

“Монолаб” ХХК нь лабораторийн шинжилгээ, туршилт судалгаа, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж,

лабораторийн оношлуур, урвалж ханган нийлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Ковид-19 цар тахлын хүнд нөхцөл, хэрэгцээ шаардлагатай үед тус компани нийгмийн хариуцлагын хүрээнд 200 сая төгрөгийн өртөг бүхий оношлуурыг эрүүл мэндийн салбарт хандивлаж байсан юм.





## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

# 2023

EXHIBITION

# МҮХАҮТ-ЫН зохион байгуулах ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ ХУВААРЬ

## ДОТООДЫН ҮЗЭСГЭЛЭН

**6 сар**

**SME<sup>s</sup>**  
Africa's Services & Technology  
INTERNATIONAL  
TRADE FAIR

ЖДҮ бүтээгдэхүүн,  
үйлчилгээ, технологи  
үзэсгэлэн

Мишээл  
экспо  
ОУУХТ

08-11



**9 сар**

**ub p**

Улаанбаатар  
түншлэл

Мишээл  
экспо  
ОУУХТ

27-30



## ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН

<b>1 сар</b>	ХБНГУ Берлин хот	Берлиний ногоон өдрүүд ОУ-ын үзэсгэлэн	өдөр 19-25
	БНТУ Измир хот	Турк Измир Агро Хүнс, ХАА Мал аж ахуйн үзэсгэлэн	31
<b>3 сар</b>	Япон улс Токио хот	Foodex Japan хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн	07-10
	АНУ Лас Вегас хот	Соп-Ехро Барилгын үзэсгэлэн	13-18
	БНСУ Сөүл хот	Олон улсын эм эмийн бүтээгдэхүүн, эмнэлэгийн тоног төхөөрөмжийн үзэсгэлэн	23-26
<b>4 сар</b>	ЯПОН Токио хот	CPHI Japan 2023 Эм, эмийн орц найрлага, эрүүл мэндийн тоног төхөөрөмж үзэсгэлэн	өдөр 19-21
<b>5 сар</b>	КАНАД Монреал хот	SIAL Canada Олон улсын хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн	09-11
<b>6 сар</b>	АНУ Нью Йорк хот	Франчайзын үзэсгэлэн	01-03
<b>8 сар</b>	БНХАУ Жилин муж Чань чунь хот	14 дэх удаагийн Хятад-Зүүн хойд Азийн экспо	
	БНХАУ ӨМӨЗО Эрээн хот	Монгол - Оросын - Хятадын 3-н талт чуулга уулзалт, үзэсгэлэн	

<b>9 сар</b>	МАЛАЙЗ Куала Лумпур хот	MIHAS Халал хүнсний олон улсын үзэсгэлэн	өдөр 12-15
	БНХАУ ӨМӨЗО Хөх хот	Монгол-Хятадын Экспо 4 дэх удаагийн үзэсгэлэн	
	ИНДОНЕЗ Жакарта хот	Mining Indonesia-2023 21 дэх уул уурхайн үзэсгэлэн	13-16
<b>10 сар</b>	БНСУ Сөүл хот	Sipremium sourcing fair-2023	27-30
	ХНБГУ Кёльн хот	ANUGA-2023 Олон улсын хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн	07-11
<b>11 сар</b>	БНХАУ Шанхай хот	Хятадын Олон улсын импортын экспо	өдөр 15-19
	ХНБГУ Берлин хот	Bazaar Berlin	05-10
	БНСУ Сөүл хот	COEX FOOD WEEK Солонгосын хүнсний үзэсгэлэн	08-12
<b>12 сар</b>	ТАЙВАНЬ Тайпэй хот	35 дахь удаагийн Тайваний барилгын үзэсгэлэн	
	БНХАУ ӨМӨЗО Хөх хот	Эрээн хотын цагаан сарын үзэсгэлэн	



7727-7070 (4)



exhibition@mongolchamber.mn

